

III ЁС ЗҮЙ

ХӨДӨЛМӨРЧ ЁС СУРТАХУУНЫ ТӨЛӨВШИЛД ТО ВАНГИЙН СУРГААЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Д.Тунгалаг

МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль

Түлхүүр үгс: Хөдөлмөр, ёс суртахуун, хариуцлага, Тогтохтөр, арвич хямгач

Хүн амьдрахын тулд тодорхой зорилго тавьж, тэрхүү зорилгоо хэрэгжүүлэх үүднээс үйл ажиллагаа явуулж, амьдрал ахуйгаа зохион байгуулдаг. Энэхүү үйл ажиллагааны нэг хэлбэр нь хөдөлмөр юм. Аливаа нийгмийн оршин тогтнох, хөгжин дэвших үндэс хөдөлмөр гэдэг нь эргэлзээгүй бөгөөд хөдөлмөр бол хүний хэрэгцээг хангахад чиглэгдсэн, материаллаг ба оюуны баялгийг бүтээн бий болгох ухамсартай, зохион байгуулагдсан нийгмийн үйл ажиллагаа билээ. Хөдөлмөр нь зөвхөн нийгмийн баялгийг бий болгохоос гадна нийгмийн гишүүдийг амьдралын хэм хэмжээнд сургаж, бие хүн төлөвших үйл явцад татан оруулдгаараа нийгмийн чухал ач холбогдолтой социал үзэгдэл, *ёс суртахууны шийдвэрлэх шалгуур* юм. Иймээс хөдөлмөр нь нийгмийн хөгжилд төдийгүй хувь хүний ёс суртахуун, зан чанарын төлөвшилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөдөлмөрийн явцад хувь хүнд *хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгодог, хөдөлмөрийг хүндэтгэдэг, ажилч хичээнгүй, ажилд хариуцлагатай ханддаг чанар, арвич, хямгач, үнэнч шудрага байдал* зэрэг ёс суртахууны үнэт чанарууд бүрэлдэн тогтдог. Мөн *хөдөлмөрөөрөө бахархах, ажлын төлөө санаа тавих, өмч хөрөнгө, эд юмсыг хайрлан хамгаалах* зэрэг нь хөдөлмөрч ёс суртахууны нэг шинж юм. Гэвч зөвхөн хөдөлмөрийн ач холбогдлыг ойлгосноор хөдөлмөрч ёс суртахуунтай болчихож чадахгүй бөгөөд гагцхүү хөдөлмөрийн явцад л эдгээр чанарууд бий болдог. Мөн хөдөлмөрийн үйл ажиллагаа нь зөвхөн биеийн хүчийг шаардаад зогсохгүй, мөн анхаарал, сэтгэн бодох, зохион байгуулах чадварыг шаарддаг. Хөдөлмөрч ёс суртахуунд харш үзэгдлүүд бол *залхуурах, бусдын хөдөлмөрийг завших, амиа бодох, эрх тушаал хөөцөлдөх буюу эрх тушаалаа буруугаар ашиглах, нүд хуурах, өмч хөрөнгө идэх, зусардан бялдуучлах, нүүр тал харах, хээл хахуул авах* явдал юм.

Манай нийгмийн харилцаа шинэ шатанд гарч, зах зээлийн эдийн

засгийн харилцаанд шилжсэнээр бэлэнчлэх сэтгэлгээний хэв маягийг халж бие даан амьдрах шинэ хэв маягийг төлөвшүүлэх хандлага бий болсон боловч өмч болон хөдөлмөрт хандах хандлага харилцан адилгүй, хөдөлмөрийн үнэ цэнийг үл ойлгох явдал ажиглагдаж байна. Тухайн нийгмийн нийт хүн амын, ялангуяа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хөдөлмөрт хандах хандлага нь тэдний оршин тогтнох, өөрчлөгдөн шинэчлэгдэхийн тулгуур үндэс байдаг. Нийслэлийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд хандах хандлагыг судалсан судалгаанаас үзвэл 51,0 хувь нь хөдөлмөрийн чадвартай бүхэн ажил хийх ёстой, 22,6 хувь нь бололцоотой бол ажил хийх албагүй, 25,5 хувь нь хөдөлмөрлөх нь хүний эрхийн асуудал учир яахаа өөрөө шийдэх ёстой¹ гэж хариулсан байна. Эндээс үзвэл, манай залуучуудын хөдөлмөрт хандах хандлага нь нийгмийн талаасаа биш хувийн талаасаа илүү хамааралтай, хөдөлмөрийн хүмүүжүүлэх ач холбогдлыг ойлгохоосоо амьдрах, мөнгө олох хэрэгсэл гэж явцуу хүрээнд ойлгох болсонтой холбоотой гэж үзэж болно. Үүний шалтгаан нь нэг талаас, нийгмийн өмчид тулгуурласан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн бэлэнчлэх сэтгэлгээний үр дагавар, нөгөө талаас, залуу үед хөдөлмөрийн хүмүүжил олгодог байсан *уламжлал алдагдасантай* холбоотой гэж үзэж болно.

Манай ард түмний гэрийн хүмүүжилд баримталж ирсэн нэг *үндсэн зарчим* нь хүнийг төлөвшүүлэхдээ алив үйлдэл, үйл ажиллагааг ямагт *ажил хөдөлмөртөй* холбон авч үздэг байсан явдал юм. Иймээс монголчууд үр хүүхдээ багаас нь хөдөлмөрч ёс суртахууныг нь төлөвшүүлэхэд анхаарч ирсэн бөгөөд энэ нь хувь хүний төлөвшил, нийгмийн хөгжилд чухал нөлөө үзүүлж иржээ. Хөдөлмөр гэдэг ойлголтыг аж амьдрал, ажил гэдэг утгатай дүйлгэхийн зэрэгцээ *ажил хийснээр хүн болж төлөвшинө* гэсэн зарчимд тулгуурлан үр хүүхдээ амжиргааны арга ухаанд сургаж байжээ. Ажил хөдөлмөрт сургах ухааныг гэрийн хүмүүжлээр олгож байснаас гадна *сургаалаар* дамжуулан тайлбарлаж, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэхийн тулд хэвшил, дадал болгодог байв. Хувь хүнийг төлөвшүүлэн ажил хөдөлмөрт сургахдаа биеэр үлгэрлэх, зааж сургахаас гадна тухайн үеийн эрдэмтэн мэргэдийн сургаалд тулгуурлан *оюун ухаан, ёс суртахуун, сэтгэхүйд* нь нөлөөлөх рациональ аргыг хэрэглэж байжээ. Ялангуяа өвөг дээдэс маань То ван хэмээх Тогтохтөрийн "Хэбэй вангийн аж төрөх сургаал"

¹ В.Отгоннасан. Нийслэлийн залуучууд ба хөдөлмөр эрхлэлт. Социологи. УБ. 2003 он. 45 дах тал.

хэмээх бүтээл дэх үзэл санааг амьдралдаа баримтлах гол зарчим болгож байсанд оршино.

То ван "Хэбэй вангийн аж төрөх сургаал" бүтээлдээ ард олны аж төрөх арга ухааныг эзэмшүүлэхийг заахдаа амьдрах ёсны уламжлалт сургаалыг үндэс болгосон байна. Энэ ном нь хүнийг хүндэтгэх, бурхан шашнаа шүтэх, мал сүргээ арчлах, ажил хөдөлмөр хийж амьдрах арга ухааныг зааж сургах сургаал бүхий дөрвөн үндсэн чиглэлтэй бичигджээ. Үүнээс мал сүргээ арчилахад хүн бүр хариулж байгаа малынхаа өвөрмөц шинж байдлыг мэдэх, тэдгээрийн арчилгаа маллагааг олон үеийн амьдралын туршлагаар олсон арга ухаанаар арчлан өсгөж өөрсдийн амьдралынхаа эх булгийг бий болгохыг заасан байдаг. Тэрээр хүмүүсийн аж төрөх, ажил хөдөлмөрт сургах сургаалаа бичихдээ ард түмний амьдралын гүн ухааны сэтгэлгээг ардын цэцэн мэргэн үгсээр илэрхийлэн гаргасан нь хөдөлмөрийн утга учир, ач холбогдол, үнэ цэнийг ухамсарлуулан ойлгуулахад чухал ач холбогдолтой юм.

То ван өөрийн сургаалдаа зөв хэрэглээнд суралцах, хөдөлмөр хийхийн ач холбогдол, улсад татвар төлөхийн зайлшгүй буюу татвараас зугтахын хор уршиг, ариулан хэмнэх, ашиг олох арга зэрэг олон асуудлыг хөндөж тавихдаа зааж сургах, ухамсарлуулан ойлгуулах аргыг хослон хэрэглэсэн нь хөдөлмөрч ёс суртахууныг төлөвшүүлэх гол үндэс болдог байжээ гэж үзэж байна. Тиймээс эдгээр асуудлыг хэрхэн авч үзсэн онцлогийг тус бүрд нь тайлбарлахыг оролдлоо.

Зөв хэрэглээнд сургах талаар. Хэрэглээ бол хүний амьдралын гол үндэс боловч зөв зохистой хэрэглээнд суралцах нь мөнгийг болон цагийг хэмнэх ач холбогдолтой зүйл юм. То вангийн сургаснаар хэдий чинээ ажил төрөлгүй байх, залхуурах нь төдий чинээ их хэрэглээг бий болгодог, хэдий чинээ ажил хийж зав чөлөө бага байх нь төдий чинээ хэрэглээг багасгаж, тэр хэрээрээ хэмнэлтгэй байна. Тэрээр энэ талаар бичихдээ: "биеийн амрыг эрэн дэмий сул суувал нойр хүрэн унтаад ажил төрлийг алдах, арай сэрж босвол дахин дахин цай ууж, бас байсан бүгдийг идэж, магад гурван өдрийн уух цай, идэх хоолыг нэг өдөр барна, тэрчлэн, гурван сарын хэрэглэлийг нэг сард барна"¹ гэжээ. Энд ажил хөдөлмөр хийдэггүй хүний хэрэглээ ажил хийдэг хүний хэрэглээнээс их байдгийг онцолжээ. Үүний учрыг ухан ойлговол, нэг талаас, ажил хийдэггүй хүн ямар их хүч хөдөлмөрөөр баялгийг

¹ Б.Тогтохтөр. Ажил ба сургуулийн зүйл. УБ. 1998 он. 20-22 дах тал.

бүтээдгийг мэдэрдэггүй, зөвхөн үрэхийг л мэддэг, нөгөө талаар, хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгодоггүй учир хэт бэлэнчлэх сэтгэлгээтэй болдгийг харуулжээ. Мөн түүнчлэн "өмсөхүйд зун илгэ, өвөл өнгө дээлд Халхын хуучин бэлэгтэй сургаалыг дагаж халиу хэрэглэн гоёх хэмээж, зуны хэрэглэх бөс даавууг өвлийн дээлийг бүү өнгөл. Малгай нударганд хурганы арьс, гутал тохомд үхрийн арьс элдэж эдэл. Ер элдэх үйлдэхийг бүү залхуур. Ийм болбасу өргүй болно" хэмээжээ. Энд энгийн хэрэглээ нь хүний амьдрал, аж төрөхийн чухал зүйл болохыг сургаж, хэт гоёх, чамирхах, тансаглах явдал хэрэглээг ихэсгэж, өр бий болох үндэс болдог, залхууралгүй хөдөлмөрлөж чадвал хэрэглээг бий болгож болдог гэдгийг харуулсан байна. Ийнхүү То ван хөдөлмөр бол зөв хэрэглээнд суралцах нэг арга болохыг харуулжээ.

Хөдөлмөр хийхийн ач холбогдлын талаар. Та вангийн сургаалын дотроос хамгийн анхаарал татхуйц сонирхолтой санаа бол хүнд биеийн хүчин үнэлэхийг одоогийнх шиг "зарцлагдах" гэдэг ойлголтоор бус харин ч ажил хөдөлмөр хийж сурах, амьдралаа өөд татах ач холбогдолтой арга хэлбэр болгон авч үзэж байсанд оршино. Энэ санаагаа тэрээр шашны сэтгэхүйд нь тулгуурлан ухамсарлуулан ойлгуулах хэлбэрээр бичжээ. Тухайлбал, "ядуу хүн олзыг түргэн олсугай хэмээвээс бусдад хүчээ үнэлэн явж буян эд малыг өөрийн юм шиг эдлэн, эрт босон, орой унтан ер зовох чилэхийг үл хэрэглэн аргал, усыг аван, арьс хөрс элдэж зогсолтгүй явж, яахан аашлан зодовч энэ намайг ажил төрөл чадахуйд сургаж байна...тиймийн тулд хүн надад сайн муу ямар загнавч би гомдохгүй, сайхан санаагаар тус хүргэн явж их буян болгоод тэр буяны үрээр энэ насанд баян болж хойтыг сайн хүн болохыг хичээсүгэй хэмээн сэтгэлийг дахин дахин засах"² талаар анхааруулан бичжээ. Үүнийг ёс суртахууны үүднээс авч үзвэл, ямар ч ажлыг үнэн сэтгэлээсээ хийж сурах, хатуу шаардлагыг зөв сэтгэлээр ойлгож сурах, хүнд тус хүргэснээр өөрийн амьдралыг дээшлүүлэх боломж бий болдгийг ухамсарлуулсан сургаал гэж үзэж болно. Тийм ч учраас "тэр баян хүн явдал санааг мэдээд өөрийн аж төрөлгүй муу хөвгүүнээсээ илүү хайрлан илүүхэн юм байснаа цөмийг өгч эд малаа эзлүүлнэ"¹ гэжээ. Нөгөө талаас, ажил төрлөө хийлгэж буй баян хүн хүний хөдөлмөрийг зүгээр завшиж болохгүй, өөртөө үнэнчээр зүтгэж байгаа хүнд ажил хөдөлмөрт суралцах, амьдралаа дээшлүүлэхэд нь туслах явдлыг

² Мөн тэнд. 32-34 дах тал.

¹ Мөн тэнд.

заан сургасан нь өнөөгийн ажилчдынхаа нийгмийн асуудлыг анхаарахын зайлшгүйтэй холбон тайлбарлаж болох юм. Энэ талаар То ван бичихдээ: "Баян хүн зарсан хүнээ боолчлон дарангуйлж үл басамжлан миний тусыг бүтээдэг тустай хүн гэж сайхан санаж түүний үл сурахыг нь төвөг яршиг гэж зөнд нь бүү явуул. Ер хяхаж бүү ашил. Түүний чадал явдал хирийг үзэж амь зуухыг өг. Ийм болбол танай ажил төрөл, явдал зарлага зөндөө бүтнэ"² гэжээ.

Татвар төлөхийн зайлшгүй буюу татвараас зугтахын хор уршигийн талаар. Өнгөрсөн нийгмийн үед алба гувчуураар ард түмнийг дарлан зовоож байсан тухай ойлголт манай нийгмийн сэтгэхүйд хүчтэй нөлөөлж байснаас биш иргэн хүн улсдаа татвар төлөх үүрэг хүлээдэг утгаар ойлгож байсангүй. Татвар төлөх нь иргэн хүний үүрэг байх ёстой гэсэн ёс суртахууны ухамсар өнөөдөр ч манайд учир дутагдалтай байгааг үүнтэй холбон ойлгож болох талтай. То ван алба өгөх явдалд ач холбогдол өгч "хүн алба өгөх явдлаас бэрхшээн залхуурч, буруу санаа үүсгэж, мал адгуусаа худалдаж бараа мөнгө болговол алба өгөхгүй амар сууна хэмээн явах хүн байх нь болзошгүй. Энэ цөвүүн цагийн хүн буян бага тул өөрийн хүчээр баяжих бэрх, харин эзэн хаанд алба дээж сайхан баривал түүний буянаар баяжиж явах нь олон. Ер нь үнэн санаагаар сүслэн алба барьдаг хүн хоосорсон удаа урьд гарсангүй, хойно ч гарсангүй нь маш үнэн. Тиймийн тул алба өгсөн хүнийг тэнгэр тэтгэдэг" гэж сургаж байжээ. Ийнхүү татвар төлөхийн ач холбогдлыг гаргахын зэрэгцээ шудрагаар татвараа төлөхгүй, алба татвараас зугтах нь өөрт эргээд хор уршигтай болохыг анхааруулсан байдаг. Тухайлбал, "заримууд дав дув шудрагыг барьж биеэр явж алба бүтээж өгөхгүй, ямагт бошго нараар өр зээл хийлгэн хураасан цаг аргагүй бариулан өрийг өгч нэгмөсөн хоосроод сүүлд, манай эд малыг албанд барин авч хоосруулав /өрөнд баригдав ДТ/ гэж хэлж, дээш нь албанд, дэргэдэх занги бошго нарт муу нэрийг гаргавасу, шийтгэж цээрлэл үзүүлбээс зохих ард мөн болой... Хоосроно хэмээгч эртний үйл. Их төлөв ухаан санааг баригдаж залхууран хойргошсоор хамаг үйл хожигдож аж төрөлгүйгээс өдөж хохирох болно. Хоосрохуйд урьдаар ухаан барагдана. Ухаантай хүн хоосроход бэрх. Ухаан барагдсан хүнд ухаан зааж тэнхрүүлэх хэрэгтэй."¹ гэж шүүмжилж байжээ. Эндээс үзвэл, То ван энэхүү алба татварын тухай сургаалаараа *нэгдүгээрт*, татвар төлөх нь иргэн хүний үүрэг болохыг

² Мөн тэнд.

¹ Мөн тэнд. 30, 32 дах тал.

хоёрдугаарт, хөдөлмөрийн явцад хүний ухамсар төлөвшиж, оюун ухаан, сэтгэн бодох чадвар төлөвшдөгийг *гуравдугаарт*, ядуурал, өр шир зэрэг нь залхуурлаас буюу хувь хүнээс өөрөөс нь хамаардаг болохыг харуулсан байна. Иймээс То вангийн алба татварын тухай энэ сургаал нь өнөө үед “иргэн бүр татвар төлөгч” гэдэг ухамсрыг бие хүнд төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой сургаал юм.

Аривлан хэмнэх, ашиг олох аргын талаар. Аривлан хэмнэх нь ёс суртахууны хувьд өмч хөрөнгөнд зөв харилцах ухамсар бөгөөд аривлан хэмнэлт нь ашгийг бий болгодог нэг хэлбэр юм. Монголчууд түүхэн цаг хугацааны аль ч үед аривлан хэмнэлтэд ач холбогдол өгч ирсэн бөгөөд гагцхүү түүнийг ойлгуулах, бодит байдал болгох арга хэлбэрээрээ ялгаатай байв. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн бодлогын нэг хэсэг нь аривлан хэмнэлт байсан боловч арга хэлбэр нь хувь хүмүүсийн ухамсарт нөлөөлхөөсөө тунхаглал, лоозонгийн хэлбэртэй байсан. Харин То ван өөрийн сургаалдаа аривлан хэмнэснээр ашиг олдог аргыг энгийн хэлбэрээр ойлгомжтой гаргажээ. Тэрээр аривлан хэмнэлтийн талаар “заримууд будаа тарьж хичнээн их ававч хэмнэн хэрэглэхийг мэдэхгүй, цай бүрт будаа чаналцаж, бас уух бүр хуурай будаа аяга дүүрэн уусаар байж нэгэн жил идэх будааг нэгэн хэдхэн сард цөмийг барна” гэж сургасан бол ашиг олох явдал нь зөвхөн мөнгийг үржүүлэн хүү болгох явдал биш хөдөлмөрөөрөө мал сүргээ өсгөх нь илүү ашиг өгдөг болохыг тооцоолжээ. Түүний тооцоолсноор “гэрт хэдий их мөнгө байвч үржихгүй байсаар хохирно. Хэрэв мөнгийг хүүлэвч нэг лан¹ ихэдвэл /их сайндаа л/ нэг жилд гурван цэн зургаан пүн² хүү төрнө. Таван цэнгийн үнэтэй эм хонь нэг жилд мөн таван цэнгийн хурга нэг хоёрыг хургалана. Хурга үхэвч арьсыг зургаан цэнгээр худалдана. Хурга байтугай арьс нь мөнгөний хүүгээс илүү гарах тул тийм их мөнгийг алдах төдийгүй төрийн тэнгэр таалахгүй” болно. То вангийн сургаал дахь ашгийн талаархи энэ үзэл санаа нь ашгийг мөнгө бий болгодоггүй хөдөлмөр бий болгодог гэсэн утга санааг илэрхийлж байгаагаараа онцлогтой.

Эцэст нь хэлэхэд То вангийн сургаал нь *ажил хөдөлмөр* гэдэг ойлголтоор дамжуулан нэгдүгээрт, ёс суртахууны үүрэг хариуцлага, шудрага хөдөлмөр, амьдралын утга учрын асуудлыг хөндсөн, хоёрдугаарт, эдийн засгийн сэтгэлгээг энгийн мэдлэгийн хүрээнд тайлбарласнаараа хүмүүсийн ухамсарт хүрч чадсан байна. Ийм ч учраас олон үе дамжин ард түмний амьдралдаа баримтлах зарчим, хөдөлмөрч ёс суртахууны хүмүүжлийн гол арга болж байгаад энэ сургаалын ач холбогдол оршино.

¹ 10 цэн нэг лан /37 грамм/
² Лангийн зууны нэг